



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/584

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай тогтоолын 3 дугаар хавсралтын 4.19 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон улсын аялал жуулчлалын ИТМ-2021 үзэсгэлэнд оролцоход зориулан 3 816 000 төгрөг /гурван сая найман зуун арван зургаан мянга/-ийг хавсралтаар батлан зарцуулсугай.

2. Дээрхи төсөл арга хэмжээг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.19-д тусгагдсан "Гурван сэнхэр төвтэй 5 од аялал жуулчлалын хөтөлбөр" арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
10 дугаар сарын 18-ны өдрийн
А/584 дүгээр захирамжийн
нэгдүгээр хавсралт

“ITM-2021” ОЛОН УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЗЭСГЭЛЭНД
ОРОЛЦОХ АЖЛЫН ТӨСВИЙН ЗАДАРГАА

Д/д	Хийгдэх ажлууд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Үзэсгэлэнгийн талбайн түрээс	м ²	18	78 000	1 404 000
2	Талбайн тохижилт	м ²	7,2	20 000	144 000
3	“Цайны зам өв соёлын наадам”, “Мөнгөлөг шагшуурга” цас мөсний баяр”-ын тараах материал /монгол, англи/	ш	1 000	1 000	1 000 000
4	“Цайны зам өв соёлын наадам”, “Мөнгөлөг шагшуурга” сурталчилгааны шторк, сурталчилгааны видео /англи хадмалтай/	ш	3	300 000	900 000
	НИЙТ ДҮН				3 816 000

Аймгийн Засаг даргын 2021 оны
10 дугаар сарын 18-ны өдрийн
А/584 дүгээр захирамжийн
хоёрдугаар хавсралт

**“ITM-2021” ОЛОН УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ҮЗЭСГЭЛЭНД ОРОЛЦОХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголын Аялал жуулчлалын холбоотой хамтран жил бүр “International Travel Mart” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг зохион байгуулдаг. “Гурван сэнхэр төвтэй таван од” аялал жуулчлалын дэд хөтөлбөр, аймгийн Ногоон хөгжлийн хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, бүс нутгийн хамтын ажиллагааг сайжруулж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, олон үндэстэн, ястнуудын язгуур урлагийг хадгалан хамгаалж, түгээн дэлгэрүүлж, дэлхий нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах хэмээн заасан байдаг.

Зорилго: Аялал жуулчлалын салбарын төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, Монголын аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, жуулчны улирлыг уртасгах, ирж буй жуулчдын тоог нэмэгдүүлэх, аймаг орон нутгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах.

Хугацаа: 2021 оны 10-р сарын 28-30.

Хийх ажлууд:

- Аймгийн аялал жуулчлалын сурталчилгаа, эвент бүтээгдэхүүн зэргийг лед дэлгэцээр сурталчлах,
- Үзэсгэлэн болох газарт 18м² талбайг аймгийн онцлогийг харуулсан байдлаар тохижуулах,
- Сурталчилгааны тараах материалуудыг хэвлүүлэн тараах.

Оролцогчид:

- Байгаль орчин, аялал жуулчлалын газар,
- Аймгийн Аялал жуулчлалын холбоо,
- Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг жуулчны бааз, зочид буудал.

ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Аймгийн Засаг даргын 2021 оны
10 дугаар сарын 18-ны өдрийн
А/584 дүгээр захирамжийн
гуравдугаар хавсралт

“ITM-2021” ОЛОН УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЗЭСГЭЛЭНД
ОРОЛЦОХ БЭЛТГЭЛ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн
1	Талбайн түрээс, талбайн тохижилт, замын зардал, томилолтын төсвийг шийдвэрлүүлэх	X/11	Л.Батбаяр
2	Талбайн тохижилт, тараах материалын эхийг бэлтгэж хэвлүүлэх	X/25	Б.Мөнхдолгор
3	Үзэсгэлэнд оролцогчдын бүртгэл, судалгаа хийж, зохион байгуулах	X/13	Б.Мөнхдолгор
4	Лед дэлгэц бэлтгэх	X/26	Б.Мөнхдолгор
5	Сурталчилгааны видео, шторкууд бэлтгэх /Аймгийн сурталчилгаа, “Цайны зам өв соёлын наадам”, “Мөнгөлөг шагшуурга” цас мөсний баяр г.м/	X/12-31	Б.Мөнхдолгор, П.Амарсанаа
6	Үзэсгэлэнд оролцож, сурталчилгаа хийх	X/28-30	Оролцогчид
7	Тавгийн идээ бэлтгэх	X/28-30	П.Амарсанаа
8	Үзэсгэлэнд оролцсон тайлан бичих	XI/06	Б.Мөнхдолгор, П.Амарсанаа,